

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 10/319

НШУС

2009

### МУЛЬТИМЕДИА СЭТГҮҮЛ ЗҮЙГ МОНГОЛД ТӨЛӨВШҮҮЛЭХ АСУУДАЛД

Б.Наранбаатар\*

\* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, магистр, докторант

**Түлхүүр үг:** мэдээллийн технологи, сэтгүүл зүй, Интернет, мультимедиа сэтгүүл зүй, мэдээллийн портал-сайт, ОНМХ.

**M**онголын сэтгүүл зүйд сүүлийн хориод жилд гарсан өөрчлөлт шинэчлэлтийн талаар янз бүрийн түвшинд хангалттай яригдаж байгаа. Үүний дотроос Монголын мэдээлэл харилцааны системд хувьсгал хийж буй үзэгдэл бол ОНМХ-ийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлүүд нэвтэрч буй явдал юм. Мэдээллийг үйлдвэрлэх, хадгалах, түгээх, хүлээн авах уламжлалт арга хэлбэрүүд шинэчлэгдэн, хүчин чадал, нөөц бололцоо, шинэ боломж нэмэгдсээр байгаа нь дээрх үйл явцын тод жишээ болно.

Мэдээллийн технологи хэмээх ойлголтын дор зөвхөн компьютер, программ хангамж, түүнтэй холбогдох техник хэрэгслийн жагсаалт эсвэл Интернет орон зайл дангаар нь авч үзэх нь өрөөсгөл юм. Сонин сэтгүүлийн эх бэлтгэх, хэвлэх технологийн шинэчлэл, радио, телевизийн дүрс дууг бичих, эвлүүлэх, дамжуулах арга нь тоон

технологид шилжсэн зэрэг олон өөрчлөлт мэдээллийн технологийн дэвшлийн үр дүн. Монголд Интернет хэрэглэгчдийн тоо хурдацтай өсөн нэмэгдэж, хэрэглээгээ даган, Интернет үйлчилгээний компани, Интернет-кафе, төрөл бурийн сайтууд олширч байна.

Аливаа нийгмийн мэдээллийн харилцааны томоохон цөм болохын хувьд сэтгүүл зүйн салбар хамгийн түрүүнд, хамгийн идэвхтэйгээр интернетжижжээшэлсэн гэхэд болно. ОНМХ-ийн уламжлалт хэлбэрүүд, сэтгүүл зүй онол, баримтлал, тэр дундаа сэтгүүлчдээс үл хамааралтайгаар мэдээлэл түргэн шуурхай солилцох, олон нийтэд хүргэх шинэ урсгал бий болсон нь аяндаа ОНМХ-үүд цахим хувилбартай болох, Интернет сонин хэвлэл, мэдээлэл хайлтын системийг бүрдүүлэх шаардлага үүсч, цаашлаад Интернет сэтгүүл зүй хэмээх шинэ ойлголтыг төрүүлсэн.

Монголд анх 1994 онд цахим шуудангийн, 1996 оноос Интернетийн үйлчилгээ нэвтэрч одоогоор Magicnet, Миком, Мобиком, Бодиком, MSC, SKY, C, Winet, Ulusnet гэх мэт 20 гаруй компани Интернетийн үйлчилгээг эрхэлж байна.

2000 оноос эхлэн Монголд Интернет үйлчилгээ, программ хангамж, цахим сүлжээний технологи эрс сайжирч төрийн болон төрийн бус байгууллагууд өөрсдийн байнгын веб хуудас ажиллуулж, банк санхүү, арилжаа, худалдааны салбарт цахим технологи өргөн тархаж, энэ төрлийн үйл ажиллагааны цар хүрээ, нэр төрөл эрчимтэй өсч байна. “Монголын хөгжлийн гарц” ТББ-ын явуулсан судалгаагаар идэвхтэй ажиллаж буй 1500 гаруй монгол веб-сайт байгаагаас 50,4% нь хувийн хэвшилийнхэнд, 30,7% нь олон нийтийн ашгийн бус байгууллагад, 9,8% нь хувь хүмүүст, 9,1% нь төрийн байгууллагуудад харьяалагддаг байна<sup>1</sup>.

ОНМХ-ийн системд мэдээллийн технологийн хөгжил хэрхэн нөлөөлж буйг ярих хамгийн энгийн жишээ бол мэдээж интернет сэтгүүл зүйн төлөвшил хөгжлийн асуудал. Өнөөгийн байдлаар Монголын үндэсний болон нийслэлийн хэмжээний ихэнх ОНМХ-үүд өөрийн веб-сайттай ба үүгээрээ дамжуулан мэдээ мэдээллээ цаг хугацаа, орон зайн хязгаарлалтгүйгээр хүргэх боломж бүрдсэн. Мөн цэвэр интернетийн мэдээллийн хэрэгслүүд, хайлтын системүүд ажиллаж буй нь цахим сэтгүүл зүйн агуулга, шинж чанарт бүрэн нийцэж, хамрах хүрээг томруулж байгаа юм. ХМХ-ийн удирдлага, ажилтнууд, судлаачид интернет сэтгүүл зүйн хөгжилөөр Монгол улс бусдаас хоцрохгүй хөл нийлүүлэн алхаж байгаа тухай ярих болсон билээ. Иймд уг асуудал дээр тогтож, арай өөр өнцөгөөс хандья.

Интернетийн тусламжтайгаар мэдээллийн хэрэгслүүд өргөх холбоог түвшин

ахиулж, иргэний сэтгүүл зүй шинээр төлөвшин хөгжиж, ОНМХ бүр мэдээллээ архивлах, хадгалах шинэлэг гарц олж, өнгө дизайн, дуу дурсний чанар дээшилсэн, мэдээллэл гэрлийн хурдтай, орон зайн хязгааргүй, хямд болсон гээд зөрөг талыг нь харж, нэг өнцөгөөс дүгнэх тал давамгайлж байна. Мэдээж дээрх бүгд биеллээ олсон ол bolt амжилт яах аргагүй мөн. Гэвч энэ бүхнээс урган гарч буй сөрөг үзэгдэл, сул тал, дутгуу ойлголт анхаарлаас гадуур үлдсээр буйг угүйсгэх аргагүй.

## Ш

инээр төлөвшин бий болж буй мэдээлэл харилцааны төрөл хэлбэрүүдийг анхнаас нь зөв залж, зохион байгуулж, мэргэжлийн хүмүүс эрдэмтэд нэр томьёоны хувьд нэгдсэн ойлголтонд хүрч онолын баримтлал, зарчмыг тодорхойлон ажиллас шаардлага урган гарч байна. Эс бөгөөс биднийг цахим технологийн ачаар сэтгүүл зүйн эргэх холбоо, иргэний сэтгүүл зүй хөгжиж байна хэмээн баярлаж суух зуур, “олон нийтийн анхаарлыг татсан асуудлыг хэлэлцэхэд өөрийн ухамсраар оролцож дуу хоолойгоо илэрхийлэх идэвхи бүхий олон нийтийг буй болгох чиглэдэг иргэний сэтгүүл зүй” нь нийтлэлийн доорх сэтгэгдэл, блог сайт хэлбэрээр хэнийг ч гутаан доромжилж, турхирч, гүтгэж, ор үндэсгүй таамаг мэдээллийг олон нийтэд цацах “хямд, үнэ цэнэгүй” хэрэгсэл болж хувирах хандлага гарч байна.

Үүний зэрэгцээ Интернет орчин олон нийтийн мэдээллийн харилцаанд шинэ боломж, шийдлийг санал болгож байхад тэдгээрийг мэдээллийн хэрэгслүүд бүрэн

дүүрэн биш юм аа гэхэд зөв ашиглах дадлага туршлага дутмаг хэвээр. Монголын, тэр дундаа нийслэлд үйл ажиллагаа явуулдаг мэдээллийн хэрэгслүүд бүгд өөрийн сайтыг ажиллуулдаг. Гэвч зарим нь цагийн шаардлагаар “албадлагын чанартай” эсвэл “моодорхож” вэб-сайттай болсноос биш түүнийг үйл ажиллагааныхаа шинэ гарц, зорилт болгож ажиллахгүй байгаа нь илт. Учир нь Монголын нэр бүхий 30 мэдээллийн хэрэгслийн вэб-сайтын үйл ажиллагааг судалж үзэхэд нэлээд хувь нь билэгдэл төдий оршиж буй нь илэрч байна. Эдгээр нь ихэвчлэн мэдээлэл шинэчлэгдэхгүй уддаг, эргэх холбоог байршуулсан ч үйл ажиллагаандaa тусгадаггүй, сонины дугаар, эфирт нэвтрэх шаардлага хангаагүй “гологдсон” материалыг сайтдаа тавьдаг зэргээс харагдана. Тухайлбал, олон нийтийн гэх тодотголтой МҮОНТВ, Боловсрол суваг телевизийн веб-сайт дахь мэдээлэл шинэчлэгдэхгүй 1-3 долоо хоносон байна.

**И**нтернет сэтгүүл зүйн онцлог нь уламжлалт ОНМХ-үүдийн мэдээлэл дамжуулах арга, техник технологийг бүгдийг нэтгэж чадсанд оршиж буй бөгөөд текст аудио, видео материалуудын багц санг бий болгсоноор хэрэглэгчдэд өргөн сонголт, хязгааргүй боломжийг нээж байна. Энэ ч утгаараа Монголын цахим хувилбартай сонин хэвлэл, өөрийн веб-сайттай мэдээллийн хэрэгслүүд Интернет сэтгүүл зүйн онцлог хэлбэр мөн давуу тал болсон мультимедиа сэтгүүл зүйг нэгдмэл ухагдахуунаар ойлгож, бүрэн ашиглаж чадаж буй эсэх асуудал чухал болжээ. Иймд Интернет сэтгүүл зүйн

эрэг сөрөг үзэгдлүүд, мэдээллийн бодит, аюулгүй байдал, сэтгүүлчдийн ур чадвар гэх зэрэг тулгамдсан асуудлыг түр хойш тавьж, мультимедиа хэмээх ухагдахууныг зөв нэг мөр ойлголцох тал дээр өөрийн саналыг дэвшүүлье.

Өдгөө шинжлэх ухаан, мэдээллийн технологийн хөгжил дэлхийн улс орнуудын мэдээлэл харилцаанд хэрхэн нөлөөлж байгааг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

*Нэгдүгээрт*, дэлхийн хаанаас ч ямарваа мэдээллийг олж авах боломж, хурд нэмэгдснээр мэдээллийг дамжуулах хэрэгслийн үнэ буурч байна.

*Хоёрдугаарт*, дуу, дүрсийг чанарын өндөр түвшинд багтаасан мэдээллийн харилцааны хэрэгслүүд улам боловсронгуй болсноор идэвхгүй сонсогч, буюу үзэгч уг харилцааны идэвхитэй оролцогч болсон

*Гуравдугаарт*, тоон технологи, техникийн дэвшил мэдээллийн орон зай илүү нэвтэрснээр мэдээллийн эх сурвалж, үйлдвэрлэгчийн тоо хязгааргүйгээр өсөн нэмэгдэнэ.

*Дөрөөдүгээрт*, нийгэм бүхэлдээ технологийн хөгжлийг амьдралд нэвтрүүлснээр хүн амын нийгэм улс төр, эдийн засаг, мэдээллийн харилцаа идэвхижнэ.

Интернетийн гол онцлог нь асар их мэдээллийн багтаамжтай, маш шуурхай, орон зай, цаг хугацааны хязгааргүй, мэдээллийн дийлэнх нь үнэ төлбөргүй, хэрэглэгч мэдээлэл тараадаг төвүүдээр үйлчлүүлэхээс гадна өөрөө мэдээлэл түгээх төв болох боломжтойд оршдог<sup>2</sup>. Иймд цахим орон зайд эмх замбараагүй байгаа мэдээллийн олон эх сурвалж сувгаас мэргэжлийн сэтгүүлчдийн үйл

ажиллагааг ялгаатай, онцлог байлгах жинхэнэ гарц мультимедиа сэтгүүл зүй байж болох юм.

Мультимедиа (латин хэлний *multum+medium*) гэдэг үг нь олон хэлбэрийн (текст, дуу, дүрс бичлэгт. м.) мэдээллийг нэг зэрэг багтаах, хадгалах, үзэх, ашиглах боломжтойгоор нэг зөөвөрлөгчид байршуулах гэсэн санааг агуулдаг. Зарим тохиолдолд энэ нэр томъёог тодорхой хэмжээний багтаамжтай олон төрөлт мэдээллийг зөөвөрлөх хэрэгслийг (тухайлбал, CD, flash disk) нэрлэх нь бий.

Сэтгүүл зүйн практикт энэ ухагдахуун орж ирснээр 2-3 янзаар ойлгогдох болов. Жишээлбэл, ихэнх OHMX-ийн ажилтан, зарим судлаач OHMX-ийн веб-сайт, эсвэл цэвэр цахим хэлбэрийн мэдээллийн хэрэгслүүд нэг цонхонд текст, дуу, дүрс бичлэгийг нэг зэрэг үзэх боломжтойгоор хэрэглэгчид хүргэх ажиллагааг мультимедиа сэтгүүл зүй хэмээн ойлгож, тайлбарлаж буй. Өөрөөр хэлбэл, news.mn сайтаас Интернет хэрэглэгч мэдээллийг дээр дурдсан бүхий л хэлбэрээр уншиж, үзэж болно. Үүнийг мультимедиа хэмээн гэж. Энэ нь буруу биш юм. Харин дутуу, өнгөц ойлголт манайд төлөвшиж буйг илтгэнэ. Уг асуудал зөвхөн Монголд бус, дэлхийн улс орон, бус нутаг бүрт сэтгүүл зүй судлаачид, практик сэтгүүлчдийн дунд сүүлийн таван жил маргаан тарьж буй бөгөөд өдгөө харин нийтээр хүлээн зөвшөөрөхүйц нэгдмэл санал гарах болов.

Тухайлбал, АНУ-ын Майамигийн Их сургуулийн Теле сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч Ричард Бекманы дэвшүүлсэн мультимедиа сэтгүүл зүйн томьёолол олны анхаарлыг татаж байна. Ричард

Бекманы удирдлага дор Миамигийн Олон улсын сэтгүүл зүйн төвийн хэсэгээр эрдэмтэд мультимедиа сэтгүүл зүй онол, практикийн хувьд боловсруулж АНУ-ын мэдээллийн системд төлөвшүүлэх ажлын хэсэгт багтан 2005 оногдаж ажиллаж эхэлжээ. “Вашингтон пост” сонин дээрх төвөөс боловсруулсан мультимедиа төслүүдийг дэмжин хэрэгжүүлж эхэлсэн ба өдгөө washingtonpost.com сайт нь Америкийн мультимедиа сэтгүүл зүйн загвар жишээ болох хүйц түвшинд хүрснийг профессор Р.Бекман<sup>3</sup> 2009 оны 4-р сард Хонконг хотноо болсон Азийн сэтгүүл зүй судлаачдын сургалт семинарын үеэр мэдэгдэж байв. Бидний дээр дурдсан олон төрлийн (текст, дуу, дүрс) мэдээллийг нэг дор агуулсан news.mn, gogo.mn эсвэл Youtube.com, google.com зэрэгээ “Вашингтон пост” сонины веб-сайтуугаар ялгарч чадав?

**Н**эг сэдэв, нэг асуудлыг хөндөж олон талаас нь сурвалжилсан сэтгүүлчдийн баг мэдээлэлээ текст, видео, аудио, фото хэлбэрээр нэгтгэн цогц байдлаар хэрэглэгчид хүргэх Интернет сэтгүүл зүйн нэг чиглэлийн мультимедиа хэмээн тодорхойлж болно. Тухайлбал, АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсон Барак Обамагийн тангараг өргөх ёслолын ажиллагаанаас жагсаалт, албан ёсны арга хэмжээний талаар видео материал, үйл явдалд оролцождын санал сэтгэгдлийн тухай фото зургаар чимэглэсэн аудио- (радиогийн хэв маягаар) сурвалжлага, Барак Обамагийн намтар, улс төрийн бодлогын талаар задлан шинжилсэн өгүүлэл гэх зэрэг нэг сэдэвт олон төрлийн математик

риалыг сайтын нэг цонхноос үзэгч сонирхож болох жишээтэй.

Ийм проектыг цаг тухай бүрд мэдээллийг нь шинэчлэн өөрчилж болох ба “Вашингтон пост”-ын дээрх “хуудас” өдгөө Ерөнхийлөгчийн явуулж буй бодлого улс төрийн алдаа оноог шүүн хэлэлцэх, дүгнэх сэтгүүлчдийн болон иргэдийн үзэл бодлын индэр болж чаджээ. Ялангуяа, АНУ-ын өнгөт арьс иргэдийн эрх ашиг, тулгардаг бэрхшээл, амьдралын хэв маягийн онцлог зэргийг харуулах зорилготой “Being a black man” төсөл амжилттай хэрэгжсэнээр “Вашингтон пост” сонины мультимедиа сэтгүүл зүйн үлгэр жишээ судлаачид бусад орны практик сэтгүүлчдэд илүү ойлгомжтой болов.

**И**ймд манай сэтгүүл зүйд хүчин зүтгэгч судлаач, сэтгүүлч бид мэдээллийн технологи, Интернет сэтгүүл зүйтэй холбоотойгоор гарч ирдэг нэр томъёо, шинэ үзэгдэл бүр дээр “монголчилсон” тайлбар яaran хийхээс өмнө, гадны жишиг, хандлага, асуудлыг шийдвэрлэж буй арга замуудаас үлгэр авч ажиллах зайлшгүй шаардлага бий.

## Ишлэл

1. 2007. Цахим Монгол хөтөлбөр 2005-2012. МХХТГ. УБ. 23 дахь тал.

1. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн товч тайлбар толь. УБ., 38 дахь тал.

3. Вескаман R. 2009. Multimedia in Digital Age// Presentation in Workshop for Journalists. Hong Kong, p. 52.

## Ашигласан бүтээлийн жагсаалт

2. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн товч тайлбар толь. УБ.

3. 2008. “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. № 9.

4. Коханова Л. 2007. Интернет-журналистика. М.

5. [www.washingtonpost.com/being a black man](http://www.washingtonpost.com/being-a-black-man)

6. Вескаман R. 2009. Multimedia in Digital Age// Presentation in Workshop for Journalists. Hong Kong.

## Резюме

В данной статье автор рассматривает особенности развития Интернет-журналистики в Монголии, уделяет внимание положительному и негативному влиянию информационных технологий на медиасферу Монголии. Автор подчеркивает, что существуют разногласия по поводу новых терминов в Интернет-журналистике, и в данном случае старается найти общий подход к понятию “мультимедиа журналистика”.